



**ОРХОН АЙМАГ  
ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 12 дугаар сарын 05

Дугаар 002/11

Жаргалант сум

**Ойгоос бэлтгэх модны  
хэмжээг тогтоох тухай**

Монгол Улсын Засаг захиргааны нэгж түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэг, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалт, 32 дугаар зүйлийн 32.3 дахь хэсэг, Байгаль орчин, аялал жуучлалын сайдын 2024 оны А/699 дүгээр тушаал, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 11 сарын 13-ны өдрийн 03/03 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

Нэг. Аймгийн 2018 онд баталсан 6 жилийн ойн зохион байгуулалтын ажлын тайлан, ойн менежментийн төлөвлөгөөг харгалзан 2025 онд сумын иргэдийн хэрэгцээнд зориулж ойн цэвэрлэгээний ажлаар хэрэглээний хуурай шинэс мод 100 шоометр, түлээний шинэс мод 800 шоометр бэлтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

Хоёр. Тус сумаас 2025 онд бэлтгэх түлшний модны нөөцийг мэргэжлийн байгууллагаар тогтоолгож, мод бэлтгэх талбайг тусгаарлуулахыг сумын Засаг дарга (Л. Учрал)-д даалгасугай.



**Ш. БИЛГҮҮНБААТАР**